

**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	3
2.1. Оршил .....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	6
2.10. Зорилтот түвшингийн орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Ц.ЦЭРЭН ТАНАА

2018.03.15 № 06/454  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Цэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 28-наас 2018 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн аудитор Д.Үүрийнтуяа, Г.Оюун, аудиторын туслах ажилтан Б.Марал нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг “Цэгцтөв Богд Аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 058 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн бөгөөд төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацааг 12 хоногоор хоцроосон байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой сэргээгдэх эрчим хүчний нөөцийн нарийвчилсан хэмжилт судалгаа хийх, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар төсөвт судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төсөл боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжид техникийн хяналт тавих, гадаад, дотоодод үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид туршилт хийх, магадлал гаргах, шинээр баригдах эрчим хүчний эх үүсгүүрийн хүлэмжийн хийн ялгарлын бууралтад магадлагаа нотолгоо хийх, сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсгүүр барих, тоног төхөөрөмж угсрах, сургалт зохион байгуулж сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн ажиллахад оршиж байна.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Улсын бүртгэлийн гэрчилгээнд “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндсэн: Нарны зайн үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн худалдаа
- Туслах: Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр туршилт, судалгаа хийх, зураг төсөл боловсруулах, зөвлөгөө өгөх

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын удирдлага дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Зөрчлийн тухай
- Сэргээгдэх эрчим хүчний тухай
- Эрчим хүчний тухай
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай,
- Нийгмийн даатгалын тухай
- ХХОАТ-ын тухай

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа гол хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Венеца” програм хангамж ашигладаг байна.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгов.

Төрийн өмчит үйлдвэрийн газар орлого олох зорилготой тул материаллаг байдлын суурийг орлоготой уялдуулсан болно.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,604.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 32.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.1 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

/сая төгрөг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	22.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
	Дүн	3	22.4	

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц дараах эрсдэлтэй асуудал байна. Үүнд:

Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу газар, барилга байгууламжийн дахин үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар



хийжээ. Үүнд тус байгууллагын эзэмшилд буй 12430.7 м.кв газрын эзэмших эрхийн бодит үнэ цэнэ 73.1 сая, 6 ширхэг барилга байгууламжийн бодит үнэ цэнэ 1,388.5 сая төгрөгөөр тус тус үнэлэгдсэн байна. Газар нь гэрчилгээгүй тул санхүүгийн тайланд тусгаагүй байна.

## **2.10. Зорилтот түвшингийн орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчит үйлдвэрийн газрын батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 1,434.7 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 681 дүгээр тогтоолоор батлуулж ажилласан байна.

Тус төлөвлөгөөгөөр нийт 1,600.3 сая төгрөгийн орлого олж 1,434.7 сая төгрөгийг зарцуулан 165.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар баталжээ. Тайлант онд гүйцэтгэлээр 1,604.9 сая төгрөгийн орлого олж батлагдсан төлөвлөгөөг 4.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Зардлын хувьд гүйцэтгэлээр нийт 1,086.6 сая төгрөгийг зарцуулж 464.1 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас <http://nrec.mn/> сайтад шилэн дансны цэсийг холбосон. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ нь [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим сайтын I) төсөв/гүйцэтгэлд 36, II) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт 36, III) бусад цэсэнд 60 мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7 зөвлөмжөөс 6 зөвлөмж бүрэн хэрэгжиж нэг зөвлөмж бүрэн биелээгүй ба зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна.

Энэ нь насжилт өндөртэй авлагыг барагдуулах ажил зохион байгуулсан боловч бүрэн барагдаагүйтэй холбоотой.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Тайлагналтай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Дансны төлөвлөгөөг Сангийн Сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-ын дагуу шинэчлээгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Дансны ангилал буруу илэрхийлэгдэх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Дансны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж мөрдөх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

#### **3.2 Урьдчилгаа дансны талаар**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Дараа тайлангаар олгосон 14.6 сая төгрөгийг тайлант хугацаанд хаагаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3. жинхэнэ хэрэгжилтийн” заалттай нийцээгүй байна.

##### **3.2.2 Эрсдэл:**

Зардал буруу тодорхойлогдох, авлага хүлээн зөвшөөрөгдөхгүй байх.

##### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Ажил гүйлгээг тайлант үед хүлээн зөвшөөрөх, авлагыг барагдуулах ажил зохион байгуулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

### **3.3 Татварын тайлагналын талаар**

3.3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд татварын авлагыг 0.9 сая, өглөгийг 6.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-д “үнэн зөв байх;” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Татварын тайлагнал буруу илэрхийлэгдэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хуулийн дагуу татварын тайланг үнэн зөв тайлагнах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018.01.01	2018.12.31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	91,713,645.21	141,184,144.65
1.1.2	Дансны авлага	51,131,308.00	48,345,208.50
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	22,387,052.07	10,733,999.10
1.1.4	Бусад авлага	24,714,440.38	24,924,467.05
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	179,717,127.09	190,067,327.91
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	25,298,128.48	52,551,184.53
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>394,961,701.23</b>	<b>467,806,331.74</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	358,323,126.01	1,772,206,689.75
1.2.2	Биет бус хөрөнгө	-0.59	1,054,544.87
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>358,323,125.42</b>	<b>1,773,261,234.62</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>753,284,826.65</b>	<b>2,241,067,566.36</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	41,058,000.64	34,694,921.97
2.1.1.2	Цалингийн өглөг	1,877,723.33	-
2.1.1.3	Татварын өр	26,087,148.20	37,379,038.51
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	58,508,345.74	50,508,345.74
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		7,611,564.03
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>127,531,217.91</b>	<b>130,193,870.25</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	127,531,217.91	130,193,870.25
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	663,670,844.58	663,670,844.58
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	178,847,922.38	1,131,277,077.24
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	53,340,848.30	53,340,848.30
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-270,106,006.52	262,584,925.99
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	625,753,608.74	2,110,873,696.11
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	753,284,826.65	2,241,067,566.36

## 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	868,811,244.90	1,592,220,375.65
2	Борлуулалтын өртөг	13,382,351.13	137,065,609.22
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>855,428,893.77</b>	<b>1,455,154,766.43</b>
4	Түрээсийн орлого	7,227,272.72	5,269,088.72
5	Хүүгийн орлого	1,892,840.68	4,199,705.26
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	145,298.00	7,700.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	438,683,449.13	883,440,958.10
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-13,189.36	3,263,990.14
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	7,090,909.09	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)	-18,773,586.90	-66,088,973.03
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>414,314,988.87</b>	<b>518,365,319.42</b>
19	Орлогын татварын зардал	42,586,555.80	54,223,269.18
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>371,728,433.07</b>	<b>464,142,050.24</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>371,728,433.07</b>	<b>464,142,050.24</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>971,285,889.56</b>	<b>1,700,759,836.41</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	913,550,000.00	1,597,675,239.35
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,169,742.00	7,072,448.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	53,566,147.56	96,012,149.06
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>890,682,937.48</b>	<b>1,274,667,807.23</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	238,534,348.94	338,725,379.84
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	80,604,896.74	98,290,241.76
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	42,690,571.00	73,187,848.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	26,941,525.00	21,845,498.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,019,130.00	16,200,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	1,412,500.00	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	194,120,790.59	183,189,378.01
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	292,359,175.21	543,229,461.62
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>80,602,952.08</b>	<b>426,092,029.18</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>9,692,840.68</b>	<b>4,199,705.26</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,800,000.00	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,892,840.68	4,199,705.26
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>343,648,385.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		343,648,385.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>9,692,840.68</b>	<b>-339,448,679.74</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		



3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>37,172,850.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	37,172,850.00
3.2.5			
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>-37,172,850.00</b>
4	Валютын ханшийн зөрүү		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>90,295,792.76</b>	<b>49,470,499.44</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,417,852.45	91,713,645.21
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	91,713,645.21	141,184,144.65

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	-	-	178,847,922.38	-	43,794,301.00	-650,442,111.50	235,870,956.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							8,607,671.91	8,607,671.91
Залруулсан үлдэгдэл	663,670,844.58			178,847,922.38		43,794,301.00	-641,834,439.59	244,478,628.37
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							371,728,433.07	371,728,433.07
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт						9,546,547.30		9,546,547.30
Зарласан ногдол ашиг								-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	-	-	178,847,922.38	-	53,340,848.30	-270,106,006.52	625,753,608.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							68,548,882.27	68,548,882.27
Залруулсан үлдэгдэл	663,670,844.58			178,847,922.38		53,340,848.30	-201,557,124.25	694,302,491.01
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							464,142,050.24	464,142,050.24
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-		-	-
Зарласан ногдол ашиг								-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				952,429,154.86				952,429,154.86
2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	-	-	1,131,277,077.24	-	53,340,848.30	262,584,925.99	2,110,873,696.11

2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	Х/н	2018		2018	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Хувь
Нийт орлого	төг	<b>1,600,280,000.0</b>	<b>1,604,960,859.8</b>	<b>-4,680,859.8</b>	<b>100%</b>
Үүнээс: Цэвэр борлуулалт	төг	1,585,000,000.0	1,592,220,375.7	-7,220,375.7	100%
Түрээсийн орлого г.м	төг	15,280,000.0	5,269,088.7	10,010,911.3	34%
Нийт зардал	төг	1,434,684,600.0	1,086,595,540.4	348,089,059.7	76%
Үүнээс: Удирдлагын зардал	төг	79,359,100.0	78,265,400.0	1,093,700.0	99%
Татварын өмнөх ашиг	төг	165,595,400.0	518,365,319.4	-352,769,919.4	313%
Цэвэр ашиг / алдагдал /	төг	165,595,399.2	464,142,050.2	-298,546,651.0	280%
төсвийн төлбөрт нийт дүн	төг	<b>230,112,290.0</b>	<b>234,508,664.2</b>	<b>-4,396,374.2</b>	<b>102%</b>
а/ Орлогын татварт	төг	16,559,540.0	78,393,017.8	-61,833,477.8	473%
б/ НӨАТ	төг	98,654,200.0	54,923,095.3	43,731,104.7	56%
в/ НДШ	төг	60,963,100.0	51,319,286.2	9,643,813.8	84%
г/ ХХОАТ	төг	46,864,670.0	43,259,088.9	3,605,581.1	92%
д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	төг	6,230,780.0	6,230,789.0	-9.0	100%
е/ Гаалийн татвар	төг	-	-	-	
ж/ Тээврийн хэрэгслийн татвар	төг	400,000.0	285,887.0	114,113.0	71%
з/ Бусад татварт	төг	440,000.0	97,500.0	342,500.0	22%
Төрийн өмчийн ногдол ашигт	төг	-	37,172,850.0	(37,172,850.0)	
Нийт ажиллагсдын тоо	хүн	32	39	-7	122%
Нийт цалингийн сан	төг	438,403,200.0	364,900,819.1	73,502,380.9	83%
Нэгж ажиллагчийн дундаж цалин	төг	1,141,675.0	950,262.5	191,412.5	83%
Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төг	-	-	-	
Нэгж бүтээгдэхүүний өртөг ЦЭХ	төг	-	-	-	
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал		0.9	0.7	0.2	76%
Хөрөнгө оруулалт	төг	414,453,400.0	397,609,430.8	16,843,969.2	96%
Нийт авлага	төг	73,500,000.0	84,003,674.7	-10,503,674.7	114%
Үүнээс: 0-5 жилийн насжилттай	төг	-	61,711,527.5	-61,711,527.5	
5-10 жилийн насжилттай	төг	-	22,292,147.2	-22,292,147.2	
Нийт өглөг	төг	<b>40,000,000.0</b>	<b>130,193,870.3</b>	<b>-90,193,870.3</b>	<b>325%</b>
Богино хугацаат өр төлбөр	төг	40,000,000.0	130,193,870.3	-90,193,870.3	
Урт хугацаат өр төлбөр	төг	-	-	-	

Огноо:	2019.03.12	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ			САГ-2019/90/СТА-ТӨҮГ
				сая төгрөг

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
			Албан тушаал	Овог нэр
3	4	5	9	10
Дансны төлөвлөгөөг Сангийн Сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-ын дагуу шинэчлээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Цэрэн Г.Эрдэнэжаргал
Дараа тайлангаар олгосон 14.6 сая төгрөгийг тайлант хугацаанд хаагаагүй	14.6	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Цэрэн Г.Эрдэнэжаргал
Санхүүгийн тайланд татварын авлагыг 0.9 сая, өглөгийг 6.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.	7.8	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Цэрэн Г.Эрдэнэжаргал
Нийт	22.4			